

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ХҮРСЭН ҮР ДҮН
(2024 оны хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр)**

2024 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн (2024 он)	Хувь
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ						
ДАГУУЛ ХОТ						
Зорилт 9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.						
144	9.5.11. Хот, тосгоныг холбосон хурдны тойрог замын дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, Монгол брэндийн худалдааны төв нээн бизнес эрхлэгчдийг дэмжинэ.	2021-2030	-	-	Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/556 дугаар захирамжаар Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Плэйтийм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх 500,000 м.кв талбай бүхий газрын асуудлыг шийдвэрлэсэн. Төслийг “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай гэрээ байгуулан хэрэгжүүлж, цогцолборын байгууламжийн гадна талын 5000 м урт хашаа, 2500 м урт тусгаарлах хашаа барьж, цахилгаан, цэвэр усны эх үүсвэрийг шийдвэрлэн ариун цэвэр болон хог хаягдлын байгууламж, тохижилт бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж төслийн талбайд 58,000 ширхэг мод тарих ажлыг зохион байгууллаа. Төслийн талбайд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Амьд хөгжмийн наадам” ТББ хамтран “Плэйтийм-2024” олон улсын хөгжмийн наадмыг 2024 оны 07 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулж гадаадын 21 улсын 52 хамтлаг, дуучид, Монгол	90

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн (2024 он)	Хувь
					Улсаас 250 гаруй хамтлаг дуучид нийт 800 гаруй хамтлаг, уран бүтээлчид 4 өдрийн турш 15 тайзнаас уран бүтээлээ хүргэж арга хэмжээг гадаад, дотоодын 71,000 гаруй хүн үзэж сонирхсон. Наадмын үеэр болон бэлтгэл ажилд 4000 гаруй түр ажлын байр бий болгож, 200 жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуй нэгж, байгууллага худалдаа үйлчилгээ зохион байгуулж, эдийн засагт 8,0 гаруй тэрбум төгрөгийг эргэлтэд оруулсан байна.	
145	9.5.12. Соёлын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, соёл, урлагийн зах зээлийг өргөжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна.	2021-2030	1,538.8 Нийслэлийн төсөв	-	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 314 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл” (2022-2027), “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ”-ний (2022-2030 он) хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: 1.Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, урсгалыг нэмэгдүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Франц соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Талын салхи” олон улсын мото наадам, “Плэйтийм” олон улсын хөгжмийн наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль”, “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”, “Японы соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд”, “Гранд тур” зэрэг	90

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн (2024 он)	Хувь
					<p>аялал жуулчлалын 15 арга хэмжээг зохион байгуулж нийт гадаад, дотоодын 352,050 хүн үзэж сонирхсон.</p> <p>2.Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах зорилтын хүрээнд Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, 800 м урт хашаа, 21 амрах сандал, 8 сүүдрэвчтэй ширээ, 60 м.кв талбай бүхий ариун цэврийн байгууламж, бохирын байгууламж болон 1500 м урт явган хүний зам, 7 амрах цэг, 1400 м.кв талбай бүхий авто машины зогсоол, угтах хаалга зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэв.</p>	
146	9.5.13. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	2021-2030	1,300.0 Хувийн хэвшил	-	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай хамтран Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, зорин очих газрыг нэмэгдүүлэх зорилгоор “Плэйтийм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төслийг Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт эхлүүлэн 500,000 м.кв талбай бүхий газарт 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгууламжийн гадна талын 5000 м урт хашаа, 2500 м урт тусгаарлах хашаа барьж, цахилгаан, цэвэр усны эх үүсвэрийг шийдвэрлэн ариун цэвэр болон хог хаягдлын байгууламж, тохижилт бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж төслийн талбайд 58,000 ширхэг мод тарих ажлыг зохион байгууллаа.	90%
		2021-2030	16.0 Хувийн хэвшил	-	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Цолмон трэйвел” ХХК, Монголын Аялал жуулчлалын холбоо хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Жуулчин төгөл” байгуулах ажлыг 2022 онд эхлүүлж 18	

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн (2024 он)	Хувь
					төрлийн 610 мод, бут сөөг тарьж суулгасан. “Ногоон хот-Иргэний оролцоо-2024” уриан дор зохион байгуулагдсан хаврын мод тарих арга хэмжээний хүрээнд “Жуулчин төгөл”-д тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа нөхөн тарилтыг хийх, шинээр мод тарих ажлыг 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж 180 мод тарьж, мөн дэлхийн аялал жуулчлалын өдөр, Монгол Улсад аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан 2024 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр аялал жуулчлалын салбарын 30 гаруй байгууллагатай хамтран 10 төрлийн 326 мод, бут, сөөг тарих ажлыг зохион байгуулав. Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Жуулчин төгөл”-д нийт 27 төрлийн 1116 мод, бут сөөг тариад байна.	
148	9.5.15. Жуулчдад зориулсан үндэсний онцлог бүхий урлаг соёлын хөтөлбөрүүд бий болгож тогтмолжуулна.	2021-2030	Нийслэлийн төсөв	Аялал жуулчлалын чиглэлээр 8 арга хэмжээ, 40,000 хүн	Монголчуудын уламжлалт ёс заншил, өв соёлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадам, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Плэйтайм” олон улсын хөгжмийн наадам, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Улаанбаатар фүүд фестиваль” зэрэг үндэсний хэв шинжийг агуулсан аялал жуулчлалын 8 арга хэмжээг зохион байгуулж нийт гадаад, дотоодын 293,000 гаруй хүн үзэж сонирхсон.	100
		2021-2030	-	-	Жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор "ХҮН" театртай хамтран "HUN TOTEM" үндэсний урлагийн тоглолт, Улаанбаатар театртай хамтран “Тал нутгийн аялгуу” үндэсний урлагийн тоглолтуудыг 2024 оны	100

Д/д	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн (2024 он)	Хувь
					05 дугаар сарын 15-ны өдрөөс 2 сарын хугацаанд зохион байгуулж 6000 гаруй жуулчин үзэж сонирхсон байна.	
Нийт дундаж 94.0 хувь						

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ГАНБОЛД

НЭГТГЭСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

СУРГАЛТ, СУДАЛГАА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН Ч.ЭНХ-ОТГОН